

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/014/НА-СТА-ТШЗ

|                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                  |
|-----------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Булган аймаг<br>2025 он | Булган аймаг дахь Төрийн аудитын дарга,<br>тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг<br>түр орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол<br>Утас: 70342580 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Г.Намчинсүрэн<br>Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn |
|-----------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу,



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

АХС-02.24 № 177  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Х.ХАЛИУНБАТ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Булган аймгийн Бугат сумын ЗДТГ 2,600.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг удирдамжгүй зарцуулсан, 13,211.0 мянган төгрөгийн ЗДНХ-ийг зарцуулахдаа зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй, 1,450.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан, 4,834.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан, төрийн захиргааны албан хаагчийн 5 жилийн тэтгэмжээс 1,907.2 мянган төгрөгийн татвар суутган төсөвт төвлөрүүлээгүй, цалин тооцоолон олгохдоо 836.7 мянган төгрөгийг илүү тооцоолон олгосон нь зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4, НӨАТХ-ийн 17.3 дахь заалт болон санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй ба бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ

632502227

санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 43 хувиар өссөн байна.

#### **Аудитын гол асуудал**

Булган аймгийн Бугат сум нь түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд хандиваар 675,000.0, орон нутгийн төсвөөс 218,887.2 нийт 893,887.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### **Бусад асуудал**

Тус байгууллага нь 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 95 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  ЖЭНХЦООДОЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хоёр: Аудит хийсэн санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн гол үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

|                                                | Үзүүлэлт                                          | 2021.12.31         | 2022.12.31.        |
|------------------------------------------------|---------------------------------------------------|--------------------|--------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                    |                    |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 76,277.5           | 90,682.0           |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 2,310,278.2        | 2,753,109.6        |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>2,386,555.7</b> | <b>2,843,791.6</b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | 2,205.7            | -                  |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 2,384,350.0        | 2,843,791.6        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>2,386,555.7</b> | <b>2,647,582.3</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                    |                    |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 2,292,063.7        | 1,966,358.8        |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 1,351,430.3        | 1,505,167.2        |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>940,633.4</b>   | <b>461,191.6</b>   |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | (2,177.8)          | (1,749.9)          |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>(2,177.8)</b>   | <b>541,677.7</b>   |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                    |                    |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 667,249.6          | 2,105,422.2        |
|                                                | Тайлант оны үр дүн                                | 938,455.5          | 459,441.6          |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>1,605,705.1</b> | <b>2,564,863.8</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                    |                    |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 2,292,063.7        | 1,966,358.8        |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 1,351,430.3        | 1,505,167.2        |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>940,633.4</b>   | <b>461,191.6</b>   |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>(10,794.0)</b>  | <b>(14,130.0)</b>  |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>-</b>           | <b>-</b>           |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>0.0</b>         | <b>(0.0)</b>       |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -                  | -                  |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -                  | -                  |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   |                    |                    |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>-</b>           | <b>998,046.5</b>   |
|                                                | Урсгал зардал                                     | -                  | 998,046.5          |
|                                                | Хөрөнгийн зардал                                  | -                  | -                  |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>-</b>           | <b>998,046.5</b>   |
|                                                | Улсын төсвөөс санхүүжих                           | -                  | -                  |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас             | -                  | -                  |

## **Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Бугат сумын ЗДТГ нь 2024 онд Засгийн газрын бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж, мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн нутгийн захиргааны байгууллага байна. Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж, мэргэшсэн төрийн албан хаагчдаар хүний нөөцийг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж, сумын хөгжилд манлайлах гэж байгууллагын эрхэм зорилгоо тодорхойлжээ.

Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Бугат шинэ хөгжил 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган ИТХ-аар батлуулж хэрэгжилтийг ханган цахим Монгол арга хэмжээний хөтөлбөр, нийгэм халамжийн үйл ажиллагааг үе шаттай цахимжуулан иргэдэд үйлчлэх үйлчилгээг ил тод хүртээмжтэй болгож ажилласан байна.

## **Дөрөв: Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 102,906.3 төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 19,124.3 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 81,182.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 2,600.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 102,906.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 87,764.8 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### **5.1 Төлбөрийн акт**

1. Шинэ хоршоо төслийн томилолтын 150.0 мянган төгрөгийн зардлыг давхардуулан олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.2.4, 20.2.5- д заасан заалтыг зөрчсөн мөн санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө зарцуулахдаа байгууллагын мэргэжилтэн, албан хаагчийн хувийн дансруу 9,346.3 мянган төгрөгийг шилжүүлэн анхан шатны баримт байхгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7-д заасан заалтыг зөрчсөн мөн санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил гүйлгээний зардлаас нийт 1,450.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.2, 20.2.4, 20.2.5 заалтыг зөрчсөн мөн санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд ЗДНХ-өөс нийт 4,834.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан заалтыг зөрчсөн мөн санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5. Үйлчилгээний албан хаагчдад 600.0 мянган төгрөгөөр нормын хувцас худалдан авахад зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.14, 8.2, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

6. Албан хаагчид 836.7 мянган төгрөгийн цалин илүү тооцоолон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.2.4, 20.2.5-д заасан заалт, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

7. Төрийн захиргааны албан хаагчийн 5 жилийн урамшууллаас татвар суутган авч төсөвт төвлөрүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.2.4, 20.2.5, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.1.3-д заасан заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

## **5.2 Албан шаардлага**

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс 13,212.0 мянган төгрөгийг зарцуулахдаа ЗД-ын зөвлөлийн хурлаар шийдвэрлээгүй холбогдох дүрэм журмыг мөрдөн ажиллаагүй нь Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын 4.1 дэх заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

2. Төрийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин 29,770.0 мянган төгрөгийн 2 төрлийн худалдан авахдаа цахим тендер зарлаагүй шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 35.2-д заасан заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3. 100 жилийн ойн баяр наадмыг баярт зориулан худалдан авсан хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2, 17.6.-д заасан заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

## **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Томилолтын зардлыг удирдамжгүй зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ангилал шинэчлэн батлах

тухай" тушаал болон санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохисгүй байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил |           | Үүнээс        |           |                 |           |         |          |                                      |                     |                                                 |     |
|--------------------|-------------|-----------|---------------|-----------|-----------------|-----------|---------|----------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                    |             |           | Төлбөрийн акт |           | Албан шаардлага |           | Зөвлөмж |          | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                    | Тоо         | Дүн       | Тоо           | Дүн       | Тоо             | Дүн       | Тоо     | Дүн      | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| Бугат сумын ЗДТГ   | 9           | 97,472.26 | 5.0           | 13,690.26 | 3.0             | 81,182.00 | 1       | 2,600.00 | 0                                    | 0                   | 0                                               | 0   |
| Дүн                | 9           | 97,472.26 | 5.0           | 13,690.26 | 3.0             | 81,182.00 | 1       | 2,600.00 | 0                                    | 0                   | 0                                               | 0   |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                                       | Нийт зөрчил |          | Үүнээс        |         |                 |     |         |     |
|--------------------------------------------------------------------------|-------------|----------|---------------|---------|-----------------|-----|---------|-----|
|                                                                          |             |          | Төлбөрийн акт |         | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|                                                                          | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн     | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /төрийн хэмнэлтийн тухай хууль/ |             |          |               |         |                 |     |         |     |
| Бугат сумын ЗДТГ                                                         | 2           | 5,434.00 | 2             | 5,434.0 | -               | -   | 0       | 0   |
| Нийт дүн                                                                 | 2           | 5,434.00 | 2             | 5,434.0 | -               | -   | 0       | 0   |